



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/628

Хэрлэн сум

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 66.3 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйл, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:

Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн:  
дарга:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга

Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга

Татварын газрын Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга

Онцгой байдлын газрын гамшгаас Хамгаалах Улсын хяналтын байцаагч

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэлийн Улсын байцаагч

2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох ажлыг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн дагуу удирдлага арга зүйгээр ханган зохион байгуулж, хэрэгжилтийн

2.

гүйцэтгэлийг танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Өнөрцолмон)-д даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 18-ны А/530 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ